



ОЛОН УЛСЫН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ УС, НАМГАРХАГ  
ГАЗАР ЯЛАНГУЯА УСНЫ ШУВУУД ОЛНООР АМЬДАРДАГ  
ОРЧНЫ ТУХАЙ РАМСАРЫН КОНВЕНЦИ

*Дэлхийн байгаль-салгаалах сан (WWF) Рамсарын конвенцийн  
товчоотой хамтран ажллах гэрээг 2002 онд байгуулсан.*

## **Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци (РАМСАРЫН КОНВЕНЦИ)**

Энэ конвенци нь Иран улсын Рамсар хотод 1971 оны 2 сарын 2-нд байгуулсан дэлхийн ус, намгархаг газар, түүний ургамал ба амьтны аймгийг хамгаалахтай холбогдсон олон улсын хамтын ажиллагааг зохицуулах зэсгийн газар хоорондын гэрээ бичиг юм.

- Тус конвенцид 138 улс орон нэгдэн орж хэлэлцэн тохирогч талууд болоод байна.
- Хэлэлцэн тохирогч талууд 111,9 сая га талбай бүхий 1382 ус, намгархаг газар нутгийг Рамсарын жагсаалтад оруулаад байна.

### **Рамсарын конвенци нь стратегийн төлөвлөгөөний зорилтоо:**

*"Ус, намгархаг газар нутгийг хамгаалах, зохистой ашиглахад үндэсний ба олон улсын хамтын ажиллагааг уялдуулсанаар дэлхий нийтээр хөгжилд хүрэх явдал юм"* гэж тодорхойлсон.

### **Рамсарын конвенцид нэгдэн орсон улс орнуудын хүлээх үүрэг, хариуцлага:**

- Хүн ба түүнийг хүрээлэн буй байгаль орчны харилцан уялдаа холбоог хүлээн зөвшөөрнө.
- Ус намгархаг газар нь усны горим болон ургамал ба амьтны аймаг ялангуяа усны шувуудын амьдрах орчны экологийн зохицуулагч болдог үндсэн үүрэгтэйг харгалзана.
- Ус, намгархаг газар нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, чөлөөт амралтын дахин нөхөн сэргээхэд туйлын бэрхшээлтэй үнэт нөөц баялаг болохыг ухамсарлана.
- Ус, намгархаг газрын ашиглалт, түүнээс үүдэн гарах хор хохирол өнөө болон ирээдүйд улам бүр өсөх хандлагатай байгааг таслан зогсоохыг эрмэлзэнэ.
- Усны шувууд улирлаар хил дамжин нүүдэллэдэг учир түүнийг олон улсын нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстойг хүлээн зөвшөөрнө.
- Жагсаалтад орсон ус, намгархаг газрын хамгаалалтыг сайжруулах, өөрийн нутаг дэвсгэр дэх ус, намгархаг газар нутгийг зохистой ашиглах талаар өөрсдийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- Өөрийн нутаг дэвсгэр дээрх жагсаалтад орсон ус, намгархаг газрын экологийн байдал нь техник технологийн хөгжил, бохирдолт болон хүний бусад үйл ажиллагаанаас шалтгаалан жагсаалтад орсон үеийнхээс өөрчлөгдсөн, өөрчлөгдөх хандлагатай байгаа бол энэ тухай нэн даруй мэдэгдэх талаар зохих арга хэмжээ авна.



Монгол Улс “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци”-д нэгдэн орохыг Улсын Их Хурал 1997 оны 6-р сарын 5-ны өдөр соёрхон баталсан.

– Монгол улсын нутаг дэвсгэрт унах хур тунадасны хэмжээ харьцангуй бага бөгөөд нийт газар нутгийн 80 орчим хувийг хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүс эзэлдэг ч 67000 км урттай 5097 гол горхи, 9582 булаг шанд, 3848 нуур цөөрөмтэй. Гэвч сүүлийн таван жилд 683 гол горхи, 1484 булаг шанд, 760 нуур цөөрөм ширгэсэн.

– Монгол орноор Номхон далай, Энэтхэгийн далай зэрэг халуун дулаан орноос Хойт мөсөн далайн эрэг, Тундр хүрэх нүүдлийн шувуудын их зам дайрдаг учраас жигүүртний зүйлийн бүрэлдэхүүн олон янз бөгөөд нэн баялаг.



© Б. Мөнхбаатар

– Их нууруудын хотгор, Монгол дагуур зэрэг ус, намгархаг газруудад жил бүр олон мянган шувууд нүүдэллэн ирж өндөглөдөг.

– Монгол оронд 466 зүйл шувуу бүртгэгдээд байгаагаас 385 зүйл нь нүүдлийн шувууд юм. Монголд 250 зүйлийн шувууд өндөглөж зусдаг ба Хойт мөсөн далайн эрэг, Тундраас 10 гаруй зүйлийн шувуу нүүдлэн ирж өвөлждөг. 50 орчим зүйлийн шувууд нүүдлийн үедээ Монгол орноор дайрч өнгөрдөг.

– Ийнхүү Монгол Улс сайтар хамгаалан, зөв зохистой ашиглах замаар ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээвэл зохих биологийн төрөл зүйлээр баялаг ус, намгархаг газар нутаг элбэгтэй орон юм. Гэвч, сүүлийн жилүүдэд усны экосистемд үзүүлэх хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл ихэссээр байна.

**Монгол улсын ус, намгархаг газрын доройтол нь дараахь үндсэн шалтгаантай :**

- ойн хэт ашиглалт
- ойн болон зэгсний түймэр
- хот суурин орчмын газар, усны бохирдол
- үйлдвэр, уурхайн усны зохисгүй ашиглалт, бохирдуулалт
- байгалийн баялгийн хууль бус ашиглалт
- бэлчээрийн талхлагдал гэх мэт.



© С. Цэцэрлэг

**Монгол улс Рамсарын конвенцид нэгдэн орсоны ач холбогдол:**

- Монгол орны нуур, ус, намгархаг газруудын олон улсын болон үндэсний ач холбогдлыг тодорхойлох, улмаар олон улсын хамгаалалтын сүлжээнд хамруулах.
- Ус, намгархаг газрыг хамгаалахтай холбогдсон олон улсын арга хэмжээнүүдэд оролцох, дэмжлэг тусламж авах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан мэдээлэл солилцох.
- Усныг экосистем, нүүдлийн шувуудыг судлах, тэдгээрийн хамгаалалтын горимыг сайжруулах, аж ахуйн элдэв сөрөг нөлөөллөөс хамгаалах, энэ чиглэлээр ажилладаг хүмүүсийн чадавхийг дээшлүүлэх.

## **Рамсарын конвенциар Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилт:**


- Монгол дагуурын дархан цаазат газрыг 1997 онд, Тэрхийн цагаан нуур, Өгий нуур, Нууруудын хөндийн бүлэг нуурууд (Бөөн цагаан, Адгийн цагаан, Таацын цагаан, Орог нуурууд)-ыг 1998 онд, Хар ус нуурын байгалийн цогцолборт газар (Хар ус, Хар, Дөргөн), Айраг нууруудыг 1999 онд, Ачит, Увс, Буйр, Ганга нуурууд болон Хурх-Хүйтний голын хөндийн нууруудыг 2004 онд Рамсарын конвенцийн бүртгэлд оруулсан.
- Уг конвенцийн Монголын Үндэсний Хороог Байгаль орчны сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна.
- Усны шувууд олноор амьдардаг ус, намгархаг газруудыг улсын тусгай хамгаалалтад авч хамгаалалтыг нь сайжруулахад анхаарч байна. Үүнд: Монгол дагуурын дархан цаазат газар (ДЦГ), Увс нуурын ай савын ДЦГ, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар (БЦГ), Хорго, Тэрхийн цагаан нуурын БЦГ, Хар ус нуурын БЦГ, Хан Хөхий-Хяргас нуурын БЦГ, Онон, Балжийн голын БЦГ, Булган голын байгалийн нөөц газар (БНГ), Яхь нуурын БНГ, Хүйсийн найман нуурын зэрэг дурсгалт газрууд
- Увс нуурын ай савын дархан цаазат газрыг НҮБ-ын шинжлэх ухаан, соёл, боловсролын байгууллагын "Хүн ба шим мандал" хөтөлбөрийн шим мандлын нөөц газрын сүлжээнд 1998 онд хамруулсаны дээр уг газрыг Дэлхийн соёл болон байгалийн өвийн бүртгэлд 2003 онд оруулсан.
- Зүүн хойт Азийн тогоруу хамгаалах олон улсын сүлжээнд 1997 онд Монгол дагуур, 2003 онд Угтамын БНГ, Хурх Хүйтний голын хөндийн нууруудыг, Зүүн хойт Азийн галуу, нугас хамгаалах сүлжээнд 2000 онд Тэрхийн цагаан, Өгий нууруудыг тус тус хамруулсан. (Рамсарын жагсаалтад орсон ус, намгархаг газрын байршилыг арын нүүрэнд үзүүлэв.)



### **Ус, намгархаг газруудын хамгаалалт, ашиглалтыг сайжруулах арга замууд:**

- Ус, намгархаг газар нутгийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах үндэсний бодлого боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх
- Усны нэгдмэл удирдлагын оновчтой зохион байгуулалтын бүтцийг бий болгож, аймаг, сум дамжсан голуудын хамгаалалтын болон ашиглалтын асуудлыг голын сав газрын хэмжээнд боловсруулан хэрэгжүүлэх замаар гол, мөрний сав газрын нэгдсэн менежмент бий болгох
- Ус, намгархаг газруудад явуулах судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлж, Олон улсын болон үндэсний ач холбогдол бүхий ус, намгархаг газрын сүлжээг өргөтгөн менежментийг нь сайжруулах
- Усны нөөцийг зүй зохистой ашиглахад иргэн бүрийн идэвхтэй санаачлагатай оролцоог бий болгохын тулд ус, намгархаг газрын ач холбогдол, хамгаалалт, ашиглалтын талаархи сургалт сурталчилгааг нэмэгдүүлж, энэ талаархи иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх

# РАМСАРЫН ЖАГСААЛТАД ОРСОН УС НАМГАРХАГ ГАЗРУУДЫН БАЙРШИЛ



Дэлхийн Байгаль Хамгаалах Сан  
(WWF)-гийн Монгол дахь  
Хэтэлбэрийн газар